

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Бугат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/41/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: huanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

“Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: В.Хуандых

Утас: 99426960 Цахим хаяг: khuash69@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	16
3.4 Материаллаг байдал .....	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
<b>3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....</b>	<b>18</b>
<b>3.8 Аудитын гол асуудал .....</b>	<b>18</b>
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт .....	19
4.1 Залруулсан алдаа.....	19
4.2 Төлбөрийн акт.....	20
4.3 Албан шаардлага .....	20
4.4 Зөвлөмж .....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	21

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

**БУГАТ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Д.ГҮЛБАДАН ТАНАА**

2022.02.25 № 244  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бугат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн одог улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

Bugat+tsetserleg-3.02

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

Bugat+тсетсерleg-3.02

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Төгрөгөөр	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,725,534.00</b>	<b>13,776,446.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	20,409.00	-
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	20,409.00	-
31110	Төгрөг	20,409.00	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	195,615.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	195,615.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	4,509,510.00	13,776,446.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	4,509,510.00	13,776,446.00
35420	Аж ахуйн материал	3,100,000.00	5,130,625.00
35460	Хүнсний материал	1,409,510.00	8,645,821.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>505,300,351.80</b>	<b>479,656,824.35</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	505,300,351.80	479,656,824.35
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	496,336,351.80	470,692,824.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	465,377,620.92	465,377,620.92
39202	Хуримтлагдсан элэгдэл	(37,360,222.32)	(56,040,333.48)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	36,790,350.00	30,225,050.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,881,584.90)	(17,327,061.46)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	85,190,836.00	79,919,126.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(49,423,299.90)	(49,104,229.63)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,553,354.00	14,553,354.00
39217	Ном	3,089,298.00	3,089,298.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	8,964,000.00	8,964,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)

39303	Бусад биет бус хөрөнгө	8,964,000.00	8,964,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>510,025,885.80</b>	<b>493,433,270.35</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>649,284.00</b>	<b>1,350,229.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	649,284.00	1,350,229.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	649,284.00	1,350,229.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	135,284.00	1,350,229.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	514,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	514,000.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>509,376,601.80</b>	<b>492,083,041.35</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	509,376,601.80	492,083,041.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	110,793,373.00	110,793,373.00
51101	Өмч: - төрийн	110,793,373.00	110,793,373.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	172,672,678.28	155,379,117.83
51210	Өмнөх үеийн үр дүн	181,398,310.58	172,672,678.28
51220	Тайлант үеийн үр дүн	(8,725,632.30)	(17,293,560.45)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	225,910,550.52	225,910,550.52
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>510,025,885.80</b>	<b>493,433,270.35</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>466,698,309.00</b>	<b>320,224,925.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>13,519,409.00</b>	<b>2,030,625.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	13,519,409.00	2,030,625.00
120002	Хүүгийн орлого	20,409.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	13,499,000.00	2,030,625.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,499,000.00	2,030,625.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>453,178,900.00</b>	<b>318,194,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	432,339,400.00	297,697,800.00

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	432,339,400.00	297,697,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	205,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	20,839,500.00	20,291,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,839,500.00	20,291,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>475,423,941.30</b>	<b>337,518,485.45</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>475,423,941.30</b>	<b>337,518,485.45</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	474,062,241.30	337,518,485.45
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	347,696,459.00	241,152,469.00
210101	Үндсэн цалин	320,194,659.00	223,866,369.00
210104	Урамшуулал	27,501,800.00	17,286,100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	46,579,200.00	32,362,500.00
210201	Тэтгэврийн даатгал	29,327,900.00	22,773,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,900,600.00	2,397,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,760,100.00	1,917,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	690,100.00	479,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,900,500.00	4,794,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,629,500.00	19,442,200.00
210301	Гэрэл, цахилгаан	925,541.00	829,200.00
210302	Түлш, халаалт	19,361,000.00	17,813,000.00
210303	Цэвэр, бохир ус	342,959.00	800,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,845,300.00	1,254,900.00
210401	Бичиг хэрэг	627,800.00	129,000.00
210402	Тээвэр, шатахуун	562,400.00	351,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	375,000.00	453,000.00
210404	Ном, хэвлэл	75,300.00	50,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,204,800.00	271,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	30,893,528.00	14,698,689.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	209,300.00	238,200.00

210502	Хоол, хүнс	29,899,428.00	14,189,189.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	784,800.00	271,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	35,000.00	210,000.00
210604	Урсгал засвар	35,000.00	210,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	125,600.00	166,600.00
210702	Дотоод албан томилолт	125,600.00	166,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	362,800.00	291,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,800.00	41,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	24,894,854.30	27,939,227.45
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,675,000.00	645,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,219,854.30	27,293,927.45
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,361,700.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	1,186,700.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,186,700.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	175,000.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	175,000.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(8,725,632.30)</b>	<b>(17,293,560.45)</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(8,725,632.30)</b>	<b>(17,293,560.45)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

				Төгрөгөөр
Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>				0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>110,793,373.00</b>	<b>225,910,550.52</b>	<b>181,398,310.58</b>	<b>518,102,234.10</b>

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Тайлант үеийн үр дүн			-8,725,632.30	-8,725,632.30
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>110,793,373.00</b>	<b>225,910,550.52</b>	<b>172,672,678.28</b>	509,376,601.80
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>110,793,373.00</b>	<b>225,910,550.52</b>	<b>172,672,678.28</b>	509,376,601.80
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>110,793,373.00</b>	<b>225,910,550.52</b>	<b>172,672,678.28</b>	509,376,601.80
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн			-17,293,560.45	-17,293,560.45
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>110,793,373.00</b>	<b>225,910,550.52</b>	<b>155,379,117.83</b>	492,083,041.35

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>453,199,309.00</b>	<b>318,194,300.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>20,409.00</b>	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	20,409.00	-
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	20,409.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,409.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>453,178,900.00</b>	<b>318,194,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	432,339,400.00	297,697,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	432,339,400.00	297,697,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	205,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		205,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	20,839,500.00	20,291,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,839,500.00	20,291,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>452,918,900.00</b>	<b>316,564,309.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>452,918,900.00</b>	<b>316,564,309.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>451,557,200.00</b>	<b>316,564,309.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	349,834,000.00	239,741,909.00
210101	Үндсэн цалин	322,332,200.00	222,455,809.00
210104	Урамшуулал	27,501,800.00	17,286,100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	46,579,200.00	32,362,500.00
210201	Тэтгэврийн даатгал	32,778,200.00	22,773,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,450,300.00	2,397,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,760,100.00	1,917,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	690,100.00	479,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,900,500.00	4,794,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,629,500.00	19,442,200.00
210301	Гэрэл, цахилгаан	925,541.00	829,200.00
210302	Түлш, халаалт	19,361,000.00	17,813,000.00
210303	Цэвэр, бохир ус	342,959.00	800,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,845,300.00	1,254,900.00
210401	Бичиг хэрэг	627,800.00	129,000.00
210402	Тээвэр, шатахуун	562,400.00	351,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	375,000.00	453,000.00
210404	Ном, хэвлэл	75,300.00	50,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,204,800.00	271,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	29,470,800.00	22,449,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	209,300.00	238,200.00

210502	Хоол, хүнс	28,476,700.00	21,939,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	784,800.00	271,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>35,000.00</b>	<b>210,000.00</b>
210604	Урсгал засвар	35,000.00	210,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>125,600.00</b>	<b>166,600.00</b>
210702	Дотоод албан томилолт	125,600.00	166,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>362,800.00</b>	<b>291,900.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,800.00	41,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,675,000.00</b>	<b>645,300.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,675,000.00	645,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,361,700.00</b>	<b>-</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,186,700.00</b>	<b>-</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,186,700.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>175,000.00</b>	<b>-</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	175,000.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>280,409.00</b>	<b>1,629,991.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>260,000.00</b>	<b>1,650,400.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>260,000.00</b>	<b>1,650,400.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>260,000.00</b>	<b>1,650,400.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	260,000.00	1,650,400.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(260,000.00)</b>	<b>(1,650,400.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>20,409.00</b>	<b>(20,409.00)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>20,409.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>20,409.00</b>	<b>-</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	317,989,300.00	318,009,709.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	317,989,300.00	318,009,709.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	317,989,300.00	318,009,709.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	239,721,500.00	239,741,909.00
210101	Үндсэн цалин	222,435,400.00	222,455,809.00
210104	Урамшуулал	17,286,100.00	17,286,100.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,362,500.00	32,362,500.00
210201	Тэтгэврийн даатгал	22,773,600.00	22,773,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,397,200.00	2,397,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,917,800.00	1,917,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	479,400.00	479,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,794,500.00	4,794,500.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,081,500.00	20,081,500.00
210301	Гэрэл, цахилгаан	1,268,500.00	1,268,500.00
210302	Түлш, халаалт	17,813,000.00	17,813,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,873,100.00	1,873,100.00
210401	Бичиг хэрэг	223,200.00	223,200.00
210402	Тээвэр, шатахуун	351,500.00	351,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	453,000.00	453,000.00
210404	Ном, хэвлэл	50,200.00	50,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	795,200.00	795,200.00
2105	<b>Нормативт зардал</b>	22,346,800.00	22,346,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	44,600.00	44,600.00
210502	Хоол, хүнс	21,939,500.00	21,939,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	362,700.00	362,700.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	210,000.00	210,000.00
210604	Урсгал засвар	210,000.00	210,000.00

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	223,200.00	223,200.00
210702	Дотоод албан томилолт	223,200.00	223,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	333,700.00	333,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	83,700.00	83,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	837,000.00	837,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	837,000.00	837,000.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	317,989,300.00	317,989,300.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	297,697,800.00	297,697,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	297,697,800.00	297,697,800.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	20,291,500.00	20,291,500.00
132001	Орон нутгийн төсвөөс	20,291,500.00	20,291,500.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		20,409.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	25	25
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14
620003	Үйлчлэх ажилтан	10	10
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	100	100
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	100	100
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	100	100
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>25</b>	<b>25</b>
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	14	14
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	11

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>205,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>205,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	205,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	205,000.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	205,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	205,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	205,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бугат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор В.Хуандых гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар хэрэгжүүлсэн.

Бугат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

Бугат сумын Хүүхдийн цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага ба “Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах” зорилтын хүрээнд хүүхдийн насны онцлогт тохируулан хөгжүүлж, эрүүл саруул, эсэн мэнд асран хамгаалж, хүүхдийн хөгжлийг дэмжин нийгэмшүүлж бие хүн болгон төлөвшүүлэх зорилготой ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн харъяа төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийдэг.

Бугат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018, 2019, 2020 оны үйл ажиллагаанд 2021 онд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба шалгалт хийсэн байна.

Цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжтэй ба эрхлэгчийн тушаалаар баталсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна. Тус цэцэрлэгийн дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар аудитад туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бугат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 475.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бугат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16.6 сая төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	20.4	-	(20.4)
Авлага	195.6	-	(195.6)
Урьдчилгаа	0.0	0.0	0.00
Бараа материал	4,509.5	13,776.4	9,266.9
Үндсэн хөрөнгө	505,300.4	479,656.8	(25,643.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>510,025.9</b>	<b>493,433.3</b>	<b>(16,592.6)</b>
Өр төлбөр	649.3	1,350.2	700.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	509,376.6	492,083.0	(17,293.5)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>510,025.9</b>	<b>493,433.3</b>	<b>(16,592.6)</b>

Мөнгөн хөрөнгийн данс оны эхэнд 0.02 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан. Оны эцэст үлдэгдэлгүй байна. Авлага дансанд оны эхэнд нийгмийн даатгалын шимтгэлийн 0.2 сая төгрөгийн авлагатай байсныг оны эцэст барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 13.8 сая төгрөг болж 9.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 2.0 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй, 22.8 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч үйл ажиллагаандаа 15.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан. Бараа материалын үлдэгдэл нэмэгдсэн нь тайлант оны худалдан авалтаас зарцуулагдаагүй хүнс, аж ахуйн бараа материалын үлдэгдэлтэй байгаатай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 479.7 сая төгрөг болж 25.6 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд үндсэн хөрөнгийн данс төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 1.7 сая төгрөгөөр нэмэгдэж, акталсан 13.5 сая төгрөгийн хөрөнгө болон үндсэн хөрөнгөнд 27.3 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой буурсан байна. Аймгийн ИТХ-ын 2021 оны 13 дугаар сарын 30-ны өдрийн 133 дугаар тогтоолоор 9.1 сая, Бугат сумын ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 18 дугаар тогтоолоор 4.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшлыг акталж, данснаас хассан байна.

Өр төлбөр дансанд оны эхэнд байгууллагад төлөх 0.5 сая төгрөгийн, цалингийн ашигт төлөх 0.1 сая төгрөгийн өглөгтэй байсныг тайлант онд барагдуулж, нийгмийн даатгалын шимтгэлд 1.4 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 492.1 сая төгрөг болж 17.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 17.3 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 320.2 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 146.5 сая төгрөгөөр буюу 31.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй орлого, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 137.9 сая төгрөгөөр буюу 29 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нийгмийн даатгалын шимтгэл, нормативт зардал байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны анх батлагдсан төсөв 322.0 сая төгрөг, тодотгосон төсөв 317.9 сая төгрөг байна.

Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 4.0 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна. Үүнд: Үндсэн үйл ажиллагааны зардлууд болох урамшуулалын зардлыг 2.1 сая, хоол, хүнсний зардлыг 15.3 сая төгрөгөөр бууруулж, цалингийн зардлыг 12.0 сая, НДШ-ийг 1.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт дүнгээр төсвийг 4.0 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 317.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 318.0 сая төгрөгийг зарцуулжээ.

Батлагдсан төлөвлөгөөндөө багтааж үйл ажиллагаа явуулсан ба оны эхэнд кассын үлдэгдэлд байсан 0.02 сая төгрөгийг цалингийн зардалд зарцуулсантай холбоотой 0.02 сая төгрөгөөр хэтрэлттэй харагдаж байна.

Нийт төсвийн 75.3 хувийг цалин, 10.2 хувийг НДШ-ийн зардал, 6.3 хувийг тогтмол зардал, 7.0 хувийг нормативт зардал 1.2 хувийг бусад зардал эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 0.2 сая төгрөгийн орлого хүлээн авч эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Бугат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Бугат сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 онд нийт 317.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 318.0 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан ба цэцэрлэгийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад тэвчиж болох урсгал зардлын төсөв 23.9 сая төгрөгийн 10 хувь 2.4 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд Бугат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл байхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Бугат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 онд шилэн дансанд оруулбал зохих нийт 119 мэдээллийн 111 мэдээллийг хугацаандаа оруулсан, 2 мэдээллийн оруулах хугацаа болоогүй ба 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Тус байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Тайлант оны төсвийн гүйцэтгэлийн 2 дугаар улирлын мэдээг байршуулаагүй, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 19.9 сая төгрөгийн орлогын 1 мэдээг байршуулаагүй, 1.4 сая төгрөгийн өр үүсгэсэн 1 шийдвэрийг оруулаагүй, тайлант оны шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 61.3 хувьтай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Шилэн дансны мэдээллээс 5 мэдээллийг хугацаа хожимдуулж байршуулсан, өр, авлага үүсгэсэн шийдвэрийг байршуулаагүй зөрчилд зөвлөмж өгөгдсөн ба Бугат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 21 тоот албан бичгээр зөвлөмжийн биелэлтийг ирүүлсэн байна.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын мөрөөр хийсэн ажлын тайланг шилэн дансанд байршуулаагүй, хэрэгжилтийг шалгаж үзэхэд зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 30.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 0.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 25.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 4.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

### **4.1 Залруулсан алдаа**

Байхгүй

## 4.2 Төлбөрийн акт

Аудитаар 0.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

1. Тайлант онд олгосон 1.7 сая төгрөгийн урамшуулалт цалингаас 0.4 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, 0.1 сая төгрөгийн цалингийн ашгийн татвар суутгаж авалгүй тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Татварын Ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.7, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.3.1 дэхь заалтууд болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урамшууллаас суутгаж аваагүй нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын санд, цалингийн татварыг орон нутгийн төсөвт тус тус нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

## 4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 25.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант оны төсвийн гүйцэтгэлийн 2 дугаар улирлын мэдээг байршуулаагүй, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 19.9 сая төгрөгийн орлогын 1 мэдээг байршуулаагүй, 1.4 сая төгрөгийн өр үүсгэсэн 1 шийдвэрийг оруулаагүй, тайлант оны шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 61.3 хувьтай, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.3.2, 6.4.5, 6.4.8 дахь заалтууд болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тайлант онд давтан гаргасан тул зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөв.

2. Бугат сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 онд нийт 317.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 318.0 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан ба цэцэрлэгийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад тэвчиж болох урсгал зардлын төсөв 23.9 сая төгрөгийн 10 хувь 2.4 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалтууд болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тэвчиж болох зардлаас хэмнэж зарцуулаагүй 2.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

3. Тус цэцэрлэг нь 2021 онд хүүхдийн хоол хүнсэнд хүнсний материалын нярвын тайлангаар өдөр бүрийн хоолны талоны дүнгээр нийт 4717 хүүхдэд 13.0 сая төгрөгийн хүнсний материал зарцуулсан ба Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор

батлагдсан хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын нормоор тооцож үзэхэд жилийн дүнгээр батлагдсан нормыг нийтдээ 1.5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарлага гаргасан байна

Энэ нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.2, 41.2.3, 45 дугаар зүйлийн 45.2, Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор баталсан “Хоолны зардлын норматив тогтоох тухай” журмын 1-т “Цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 2475 төгрөгөөр тогтоосугай.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор батлагдсан хүүхдийн нэг өдрийн хоолны нормативыг баримталж ажиллах талаар албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал

###### 1.1. Илрүүлэлт:

Цалин, гэрэл цахилгаан, бичиг хэрэг, шуудан холбоо, интернетийн төлбөр, ном хэвлэл, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, эм, нормын хувцас, зөөлөн эдлэл, урсгал засвар, томиллолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх нийт 3.7 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан, 0.7 сая төгрөгийн бараа материалыг орлогод авалгүй шууд зардлаар гаргасан байна.

###### 1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1 14.4, 14.4.5 дахь заалтуудыг мөрдөж худалдан авсан бараа материалыг орлого авч тооцоо хийх, шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Буянт сумын Хүүхдийн цэцэрлэг	5	30.2			1	0.5	3	25.3	1	4.4